



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	7
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	7
2.8.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал.....	11
3.2	Хөрөнгө оруулалтын ажлын чанарын баталгаа, барьцаа хөрөнгийн данстай холбоотой асуудал	11
3.3	Тайлангийн нэгтгэл	12
3.4	Шилэн данс.....	12
3.5	Авлагын данстай холбоотой асуудал.....	13
3.6	Техник хяналтын данстай холбоотой асуудал.....	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.5	Аудит хийгдсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5	Хавсралт.....	20
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТХН	Төсөл хөтөлбөрийн нэгж
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Х.БАДЕЛХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 861

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР





2 Аудитын тайлан

2.1. Оршил

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Х.Баделхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын дүнд үндэслэсэн төсвийн төлөвлөлт, өр төлбөр, тайлангийн нэгтгэл, түүвэрт хамрагдсан байгууллагуудад барьцаа хөрөнгө, техник хяналтын зардлын данстай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 5-наас 2019 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Энхжин гүйцэтгэв.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 1057 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар, САГ-2019/29/СТА-ТЕЗ



аргачлалын дагуу горим, сорилыг гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг хийлгэн холбогдох нотлох зүйлсийг баталгаажуулан баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

БХБЯ нь Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлагын хүрээнд 7 стратегийн зорилтыг хангахад чиглэсэн 35 үйл ажиллагааны зорилтын хүрээнд 293 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

БХБЯ-ны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 90.6 хувийн хэрэгжилттэй байна.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын удирдлага Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд холбогдох хууль эрх зүйн акт болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудад нэмэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь салбарын хэмжээнд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа тул санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Засгийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн “Э-Тайлан” програм хангамжийг ашигласан байна.

Санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад удирдлагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай САГ-2019/29/СТА-ТЕЗ



илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгосон нь урсгал болон хөрөнгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг тул зардлын гүйлгээг эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 30,662.4 сая төгрөгийн 1 хувь буюу 306.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 143,679.2 сая төгрөгийн 1 хувь буюу 1,436.8 сая төгрөгөөр өөрчлөн тогтоов.

Энэ нь төлөвлөлтийн шатанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэгдээгүй байсан тул материаллаг байдлын түвшинг эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар тогтоосонтой холбоотой.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 16 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 10 байгууллага аудитад хамрагдсан ба санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

/тоогоор/

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	1	4	-	-
2	Төсөл хөтөлбөрийн нэгж	5	2	-	-
3	Төрийн өмчит үйлдвэрийн газар	3	-	-	-
4	Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	-	-	-
Дүн		10	6	-	-

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/156 дугаар тушаал

Аудитаар 4 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 6 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн байна.



2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 23,802.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 68.2 хувь буюу 16,244.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2.3 хувь буюу 535.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.1 хувь буюу 1,205.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 24.4 хувь буюу 5,817.1 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Төсвийн шууд захирагчийн аудитаар 74.9 сая, төсөл хөтөлбөрийн нэгжид хийсэн аудитаар 292.4 сая, төрийн өмчит үйлдвэрийн газруудад хийсэн аудитаар 7,492.2 сая, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээр 294.5 сая, төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд 8,090.3 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2. Алдаа, зөрчил, түүний шийдвэрлэлт.

/сая төгрөг/

№ Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс: Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	1 Төсвийн шууд захирагч	8	418.2	3	246.1	1	14.6	4
2 Төсөл хөтөлбөрийн нэгж	5	5,536.3	-	-	-	-	5	5,536.3
3 Төрийн өмчит үйлдвэрийн газар	20	1,557.0	1	289.5	4	1,177.2	15	90.3
4 Төсвийн төвлөрүүлэн захирагч	3	46.3	-	-	1	13.3	2	33.0
5 Төсвийн ерөнхийлөн захирагч	4	-	-	-	-	-	4	-
Дүн	40	7,557.7	4	535.6	6	1,205.1	30	5,817.1

Эх сурвалж: 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг тоймлон харуулбал:

Төсвийн шууд захирагчийн аудитын талаар:

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээнд 5 Төсвийн шууд захирагчийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөгдөж, 4 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулав. Үүнд:

- БХБС-ны 2018 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн бөгөөд нийт 21.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 6.0 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж, 14.6 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 1.0 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт өгөгдсөн байна.
- БХБС-ны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тайлан, техник хяналт, тусгай зориулалтын шилжүүлэг, ашиглалтын өмнөх захиргааны 2018 оны санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулан шалгахад нийт 396.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 151.5 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж, 245.1 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тус тус тогтоосон болно.

Төсөл хөтөлбөрийн нэгжийн аудитын талаар:



БХБС-ын эрхлэх асуудлын хүрээнд 7 ТХН-ийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөгдөж, 2 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулав. Үүнд:

- Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн 2018 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдөж, 44.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрч аудитын явцад улсын төсөвт төвлөрүүлж зөрчлийг залруулав.
- Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл 133.5 сая төгрөгөөр, Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл 5,391.6 сая төгрөгөөр тус тус батлагдсан төсвийг хэтрүүлсэн зөрчил илэрч “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн байна.
- Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ын хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл, Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээний төслийн 2018 оны санхүүгийн тайланд тус тус зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.
- Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл, Тайшир-Алтай төслүүдийн санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитаар түүвэрт хамруулав.

Төрийн өмчит үйлдвэрийн газрын аудитын талаар:

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээнд 3 ТӨҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдэв. Үүнд:

- “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд нийт 1,353.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 54.4 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж, 1,009.2 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 289.5 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт;
- “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд нийт 18.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч тус тус “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн байна.
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн бөгөөд нийт 185.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 17.6 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж, 168.0 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага тус тус өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитын талаар:

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээнд ГЗБГЗЗГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 21 аймаг, нийслэлийн Газрын харилцаа, хот байгуулалтын газрын санхүүгийн тайланг нэгтгэж 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 46.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 13.3 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 33.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдөж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн байна.

2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг аудитын явцад залруулж 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.



Аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагуудын илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг тус тус В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Барьцаа хөрөнгө

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тайланд ГЗБГЗЗГ-т өгөх өглөгөөр бүртгэсэн 159.6 сая төгрөгийг тус газар авлагаар бүртгээгүй бөгөөд тухайн хөрөнгийг 2011 оноос хойш барьцаа хөрөнгийн дансанд байршуулж байна.

Шийдэл:

Төлбөрийн акт тогтоох

Асуудал 2: Техник хяналтын зардал

Техник хяналтын дансанд төвлөрсөн 85.5 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Шийдэл:

Төлбөрийн акт тогтоох

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Норм, нормативын сангийн хөрөнгийн төлөвлөлт, орлого бүрдүүлэлт, зарцуулалтын талаар нарийвчилж үзэх шаардлагатай.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар нийт 2,158.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас 2,232.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь 1,815.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, тайлант онд 2,232.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 23.0 хувиар буюу 417.1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн,
- Гадаадын зээл, тусламжаас 343.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр гадаад зээл, тусламжаас санхүүжих орлогын төлөвлөгөөг биелээгүй байна.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчид 3 хөтөлбөрийн хүрээнд 16 арга хэмжээнд нийт 137,233.3 сая төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдсан байна. Үүнд:

- Урсгал үйл ажиллагааны зардалд 15,131.3 сая төгрөг,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд 80,338.4 сая төгрөг,
- Гадаад тусламжаас санхүүжих зардалд 41,763.6 сая төгрөг.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.



2.11. Шилэн дансны мэдээлэл

БХБС нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын 2018 оны шилэн дансны тайланд дурдсанаар тайлант хугацаанд нийт оруулбал зохих 66 мэдээллээс хугацаандаа оруулсан 30 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 34, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд 4 зөвлөмж, 2 албан шаардлага өгөгдсөнийг 100 хувь биелүүлэн ажилласан байна.

БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг нэгтгэж 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид БХБС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдсан.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны батлагдсан төсөвт Норм, нормативын сангийн орлого, зардлыг төлөвлөж батлуулаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн тусгахгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 33.2-т "Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална", 33.2.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого" гэж заасны дагуу норм нормативын орлого, зардлыг төсөвт тусгаж, батлуулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвшөөрсөн болно.

3.2 Хөрөнгө оруулалтын ажлын чанарын баталгаа, барьцаа хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

БХБЯ-ны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тайланд 13,178.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 13,178.3 сая төгрөгийн байгууллагад өгөх өглөгтэй тайлагнасан байна. Тус яамны өглөгийн насжилтын судалгааг харахад зарим барьцаа хөрөнгө нь 2007 оноос хойш барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна.

3.2.2 Эрсдэл:



Энэ нь жил бүр Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өглөг өндөр дүнтэй харагдах, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өндөр байх шалтгаан болж байна.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Барьцаа хөрөнгийн дансанд он удаан жил болсон, гүйцэтгэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй хөрөнгийг барьцаанаас чөлөөлж, улсын төсвийн орлого болгох, хариуцлагын асуудлыг гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд тодорхой тусгах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвшөөрсөн болно.

3.3 Тайлангийн нэгтгэл

3.3.1 Илрүүлэлт:

ГЗБГЗЗГ нь өөрийн харьяа 21 аймаг, нийслэлийн санхүүгийн тайланг нэгтгэж Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж тайлагнадаг боловч Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймаг орон нутгийн газрын харилцаа, хот байгуулалтын газрын санхүүгийн тайланг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаар нэгтгэж ГЗБГЗЗГ-ын нэгтгэсэн тайланд устгах бичилтийг хийж тайлагнаж байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд давхцал үүсэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2014 оны 128 дугаар тогтоолоор ГЗБГЗЗГ-ыг Төсвийн төвлөрүүлэн захирагч байхаар тогтоосон боловч дээрх тогтоол нь Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх”, 61.1.5-д “Газрын харилцаа, кадастр” гэсэн заалтууд нь хоорондоо зөрчилдөж байгаа учир холбогдох дээд шатны байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвшөөрсөн болно.

3.4 Шилэн данс

3.4.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт оруулбал зохих 66 мэдээллээс хугацаандаа оруулсан 30 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 34, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.4.2 Эрсдэл:

Төсвийн зарчим алдагдах, төсвийг зориулалт бусаар зарцуулах.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвшөөрсөн болно.

Менежментийн захидалд дурдсан цаашид Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:



3.5 Авлагын данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Техник хяналтын 27.0 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг “БХТ” ТӨААТҮГ-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн тоон мэдээлэл буруу илэрхийлэгдэх.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвшөөрсөн болно.

3.6 Техник хяналтын данстай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

БХБС-ын 2017 оны 172 дугаар тушаалаар Техник хяналтын дансанд төвлөрсөн хөрөнгийг захиалагчийн хяналтын чиг үүргийн дагуу “БХТ” ТӨААТҮГ-т шилжүүлсэн боловч ГЗБГЗЗГ-ын захиалагчийн хяналт хэрэгжүүлэх 124.5 сая төгрөгийн хөрөнгийг ГЗБГЗЗГ-т шилжүүлээгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Хяналт сул байх.

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Техник хяналтын дансанд төвлөрсөн 124.5 сая төгрөгийг / "Шинээр тавихаар төлөвлөж байгаа төмөр замын дагуу GPS-ийн сүлжээ байгуулах, 1:25000 масштабтай байр зүйн зураглал хийх"/ захиалагчийн хяналтын чиг үүргийн дагуу ГЗБГЗЗГ-т шилжүүлж, цаашид техник хяналтын дансны Төв төрийн сан дахь 100900029370 тоот дансыг хааж, хаалтын баланс бэлтгэх.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
Эргэлтийн хөрөнгийн дүн	473,955,868.0	469,109,108.0
Мөнгөн хөрөнгө	27,567,021.3	29,478,633.2
Авлага	134,977,930.5	142,264,748.0
Урьдчилгаа	3,080,878.0	13,245,249.4
Бараа материал	61,401,688.6	31,233,918.2
Нөөцийн бараа	25.7	-
Бусад эргэлтийн хөрөнгө	246,928,323.9	252,886,559.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	351,291,840.4	427,693,059.9
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000.0	1,000.0
Урт хугацаат зээл	1,000.0	1,000.0
Үндсэн хөрөнгө	351,290,840.4	427,692,059.9
Биет хөрөнгө	350,208,292.8	358,672,238.0
Биет бус хөрөнгө	152,488.4	67,935,987.1
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	930,059.2	1,083,834.8
Нийт хөрөнгийн дүн	825,247,708.4	896,802,167.9
Нийт өр төлбөр	396,899,835.9	405,630,753.2
Богино хугацаат өр төлбөр	97,972,931.0	118,600,729.7
Өглөг	67,279,728.0	97,048,313.9
Урьдчилж орсон орлого	30,693,203.0	21,552,415.8
Урт хугацаат өр төлбөр	298,926,904.9	287,030,023.4
Урт хугацаат зээл	298,926,904.9	287,030,023.4
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	428,347,872.5	491,171,414.7
Засгийн газрын хувь оролцоо	428,347,872.5	491,171,414.7
Засгийн газрын оруулсан капитал /засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,478,158.8	2,581,158.8
Өмч /төрийн/	8,247.3	66,706,381.2
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	307,592.9	307,592.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	5,553,814.7	6,454,792.0
Хуримтлагдсан үр дүн	419,952,215.3	414,008,525.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	47,843.5	1,112,964.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	825,247,708.4	896,802,167.9



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
Үйл ажиллагааны орлогын дүн	170,880,324.7	183,663,062.8
Татварын орлого	-	-
Татварын бус орлого	45,946,008.9	98,948,390.7
Нийтлэг татварын бус орлого	45,946,008.9	98,948,390.7
Тусламж, санхүүжилтийн орлого	124,934,315.8	84,714,672.1
Үйл ажиллагааны зардлын дүн	112,220,707.6	143,395,440.2
Урсгал зардал	112,215,635.4	143,329,342.1
Бараа, ажил үйлчилгээний зардал	102,591,298.4	129,991,665.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,095,211.6	2,831,504.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	333,558.3	329,312.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	272,475.9	192,454.3
Хангамж, бараа материалын зардал	66,884,781.4	99,730,915.3
Нормативт зардал	904.0	-
Эд хогшил, урсгал засварын зардал	42,094.1	32,029.9
Томилолт, зочны зардал	85,057.7	163,998.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,406,119.7	24,990,265.3
Бараа үйлчилгээний бусад зардал	1,471,095.6	1,721,186.2
Хүү	7,260.2	67,707.9
Татаас	6,040.0	-
Урсгал шилжүүлэг	9,611,036.9	13,269,968.8
Хөрөнгийн зардал	5,072.1	66,098.0
Үйл ажиллагааны үр дүн	58,659,617.2	40,267,622.6
Үйл ажиллагааны бус орлогын дүн	67,627.1	141,649.9
Үйл ажиллагааны бус зардлын дүн	3,032,261.1	5,502,815.5
Үйл ажиллагааны нийт үр дүн	55,694,983.1	34,906,457.0



4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	158,319,938.1	155,597,331.4
Татварын орлого	-	-
Татварын бус орлого	77,561,613.9	70,298,906.1
Нийтлэг татварын бус орлого	77,561,613.9	70,298,906.1
Тусламж, санхүүжилтийн орлого	80,758,324.2	85,298,425.2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	33,666,097.4	43,554,184.5
Урсгал зардал	33,666,097.4	43,554,184.5
Бараа, ажил үйлчилгээний зардал	23,925,415.0	30,578,748.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,968,368.4	6,067,497.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,303,952.4	1,559,770.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	279,763.4	255,147.8
Хангамж, бараа материалын зардал	7,019,521.4	6,297,660.6
Нормативт зардал	1,538.9	629.1
Эд хогшил, урсгал засварын зардал	27,983.4	24,594.1
Томилолт, зочны зардал	144,823.7	295,255.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,114,319.6	5,143,944.9
Бараа үйлчилгээний бусад зардал	4,065,143.9	10,934,248.2
Хүү	-	-
Татаас	-	-
Урсгал шилжүүлэг	9,734,642.4	12,975,435.7
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	124,653,840.7	112,043,146.9
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	298,529.8	384,509.4
Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	67,202,366.7	85,078,511.6
Хөрөнгийн зардал	67,202,366.7	85,078,511.6
Дотоод эх үүсвэрээр	67,202,366.7	85,078,511.6
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-66,903,836.9	-84,694,002.2
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-46,009,167.6	-25,437,532.8
